

## **МОНГОЛ УЛС, АНУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ЦААШДЫН ТӨЛӨВ**

***БХЭШХ-ийн АББХС-ын төвийн ЭША,  
хурандаа И.Батболд,***

***БХЯ-ны ГХА-ны ахлах мэргэжилтэн,  
хурандаа Ш.Амарбаясгалан***

Монгол Улс ба АНУ-ын (цаашид Монгол-Америкийн гэх) Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагаа нь 1991, 1992 онд батлан хамгаалахын атташег харилцан суулгаснаар эхэлсэн түүхтэй. Энэ харилцаа харьцангуй богино хугацаанд Монгол-Америкийн түншлэлийн харилцааны үндсэн нэг тулгуур болон хөгжиж чадсан. Хоёр орны батлан хамгаалах, зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагаа нь батлан хамгаалах бодлогыг харилцан хүндэтгэж, үйл ажиллагаа нь харилцан ашигтай байхад чиглэсэн зөвшилцлийн хэлбэрээр явж ирсэн.

Энэ харилцаа, хамтын ажиллагаа нь батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгуулалтыг шинэчлэх, батлан хамгаалах салбар дахь иргэний хяналтыг бэхжүүлэх, батлан хамгаалахын нөөцийн удирдлагыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Зэвсэгт хүчний шинэчлэлд их хувь нэмрээ оруулсан гэж дүгнэж болохоор байна. Зэвсэгт хүчний шинэчлэлийн нэг чухал хэлбэр болсон энхийг дэмжих ажиллагааны чадавхийг өргөжүүлэхэд АНУ-ын санхүүгийн болон материал-техникийн тусламж ихээхэн үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэх нь зүйтэй. Бий болсон чадавхид тулгуурлан Энхийг дэмжих ажиллагаа,

терроризмын эсрэг явуулж байгаа олон улсын эвслийн ажиллагаанд зэвсэгт хүчнийг оролцуулж эхэлсэн. Энэ нь олон улсын тавцан дахь Монгол Улсын нэр хүндийг өсгөж, дэлхийн болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдалд Монгол Улс өөрийн хувь нэмрээ оруулах боломжийг олгосноор Монгол-Америкийн батлан хамгаалах, зэвсэгт хүчний хамтын ажиллагааны хамгийн том ололт болсныг онцлон тэмдэглэж байна.

Монгол-Америкийн батлан хамгаалах, зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагааг дараах үндсэн чиглэлээр тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Монгол Улсын батлан хамгаалахын өөрчлөлт, шинэчлэлд үнэлгээ өгөх, цэргийн сургалтад дэмжлэг үзүүлэх, орчин үеийн цэргийн боловсролын тогтолцоог бий болгох;
- Энхийг дэмжих ажиллагааны чадавх болон олон талт үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх замаар Зэвсэгт хүчний цэргийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх;
- Ази-Номхон далайн бүс нутгийн батлан хамгаалах, аюулгүй байдлын олон талт хамтын ажиллагаан дахь Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэх, аюулгүй байдлын чиглэлээр мэргэжилтэн болон мэдээллийг харилцан солилцох, бүс нутгийн цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах зэрэг болно.

### **Эрх зүйн үндэс**

Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь хоёр улсын хууль, эрх зүйн хүрээнд тулгуурлаж байх учиртай тул энэ батлан хамгаалах, зэвсэгт хүчний хамтын ажиллагааг гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр явуулах зорилгоор хоёр тал олон гэрээ, хэлэлцээрийг дэс дараатай байгуулж иржээ. Тухайлбал:

- 1996 онд “Цэргийн айлчлал, солилцооны тухай Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр”
- 2003 онд Цэргийн ар талын хэрэглээ, үйлчилгээний асуудлыг зохицуулах тухай “Монгол Улсын Батлан хамгаалах яам, АНУ-ын Батлан хамгаалах яам хоорондын хэрэглээ, харилцан үйлчилгээний Хэлэлцээр”;
- 2003 онд “Олон улсын эрүүгийн шүүхийн хуулийн 98 дугаар

зүйлийн талаарх Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр”

- 2008 онд “Монгол Улсын Батлан хамгаалах яам, АНУ-ын Батлан хамгаалах яам хоорондын Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хамтарсан тунхаглал”;
- Монгол Улсын Батлан хамгаалах яам, АНУ-ын Аляска мужийн Үндэсний гвардитай “Улс, муж хоорондын түншлэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд хамтран ажиллах тухай “Харилцан ойлголцох санамж бичиг”;
- Монгол Улсын Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, АНУ-ын Цэрэг, иргэний харилцааны төвтэй сургалт, судалгааны талаар хамтран ажиллах тухай “Харилцан ойлголцох санамж бичиг”;
- Монгол Улсын Батлан хамгаалахын их сургууль, АНУ-ын Виржиний цэргийн сургуультай хамтран ажиллах тухай “Харилцан ойлголцох санамж бичиг”;
- 2015 онд “Афганистан Улсад үүрэг гүйцэтгэх Монгол Улсын томилгоот хүчний үүрэг гүйцэтгэлтийн асуудлыг зохицуулах Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штаб, АНУ-ын Төвийн командлал хоорондын техникийн гэрээ”-г зэрэг болно.

Эдгээр гэрээ, хэлэлцээр нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны бүхий хэлбэрийг хамарч, үйл ажиллагааг хоёр улсын эрх зүйн хүрээнд явуулах боломжийг олгохын хамт үйл ажиллагааг зохицуулах, хоёр талын эрх үүргийг тогтоосон гэрээ, хэлэлцээр гэж хоёр хэсэг ангилж болох юм.

### **Харилцан айлчлал**

Батлан хамгаалах, зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагааны нэг чухал арга хэмжээ нь хоёр талын өндөр түвшний албан тушаалтны харилцан айлчлал байдаг. Энэ айлчлалын явцад дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчин, нөхцөл байдлын тухай байр суурь, мэдээллийг харилцах солилцох, батлан хамгаалах, зэвсэгт хүчний өнөөгийн тулгамдаж байгаа асуудлууд, хамтын ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл, цаашдын төлвийн

талаар ярилцаж, зөвшилцөлд хүрдэг билээ. Харилцан айлчлалыг хэрэгжүүлсэн байдлыг харахад Батлан хамгаалах дээд хэмжээний удирдлага, цэргийн дээд удирдлагын түвшинд хийсэн айлчлал гэж 2 томоохон бүлэг хуваах боломжтой юм.

АНУ-ын талаас Монгол Улсад 2005, 2014 онд АНУ-ын Батлан хамгаалахын сайд, 2000, 2010 онд АНУ-ын Батланхамгаалах яамны орлогч сайд, 2015 онд АНУ-ын Батлан хамгаалахын туслах сайдын орлогч нар, АНУ-ын БХЯ-ны Ази, Номхон далайн орнуудын Аюулгүй байдлын асуудал эрхэлсэн дарга, 2015 онд АНУ-ын Батлан хамгаалах яамны Зүүн Азийн асуудал эрхэлсэн туслах нарийн бичгийн дарга Абрахам Денмарк, АНУ-ын Сенатын Батлан хамгаалах хорооны гишүүн сенатор Жон Маккейн, Шелдон Уайтхаус нартэргүүтэй төлөөлөгчид, 2016 онд АНУ-ын Батлан хамгаалах яамны Зүүн Азийн асуудал эрхэлсэн туслах нарийн бичгийн дарга Абрахам Денмарк тэргүүтэй төлөөлөгчид тус тус айлчилжээ.

Цэргийн дээд удирдлагын түвшинд 2004 онд АНУ-ын штабын дарга нарын нэгдсэн хорооны дарга, 1992, 1994, 1995, 2000, 2004, 2006, 2007, 2011, 2013 онуудад Номхон далай дахь АНУ-ын Цэргийн хүчний командлагч, 2012 онд Номхон далай дахь Хуурай зам, Тэнгисийн цэргийн асуудал эрхэлсэн сайд нар, Номхон далай дахь Хуурай замын цэргийн командлагчийн орлогч, Аляск мужийн Үндэсний гвардийн командлагч нар, 2013 онд Аляск дахь АНУ-ын Хуурай замын цэргийн хүчний командлагч, Номхон далай дахь АНУ-ын Тэнгисийн болон Хуурай замын цэргийн командлагч, 2015 онд АНУ-ын Аляск мужийн үндэсний гвардын командлагч, бригадын генерал Лаури Хаммел, 2016 онд Номхон далай дахь АНУ-ын цэргийн хүчний командлалын АУГ-ын орлогч, бригадын генерал Жонн Хиляр, АНУ-ын Агаарын хүчний Командлагчийн Үндэсний гвардын нисэх хүчний асуудал эрхэлсэн орлогч хошууч генерал Майк Комптон, Номхон далай дахь АНУ-ын Цэргийн хүчний командлагч Адмирал Харри Харрис нар тус тус айлчилжээ.

Монголын талаас 1995, 1997, 2011 онуудад Монгол Улсын Батлан хамгаалахын сайд, 1996, 2010, 2015 онд Монгол Улсын Батлан хамгаалахын дэд сайд, 2015 онд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал З.Болдбаатар, 1993, 2002, 2003, 2004, 2005, 2006, 2008,

2012, 2015 онд Монгол Улсын ЗХЖШ-ын дарга, 2016 онд ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбат тэргүүтэй төлөөлөгчид тус тус айлчилсан байгаа хоёр талын харилцан айлчлалын давтамж, түвшин дэс дараатай хангаж ирсэн харагдаж байна.

Монгол-Америкийн батлан хамгаалах салбарын удирдах албан тушаалтнуудын харилцан айлчлал нь тогтмолжиж, эдгээр айлчлал нь хоёр талын батлан хамгаалах салбарын харилцааг гүнзгийрүүлэх, хамтын ажиллагааны явц байдалд үнэлэлт өгөх, хэтийн төлвийг тодорхойлох, зэвсэгт хүчний цэргийн багуудыг Эвслийн ажиллагаанд оролцуулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулж ирлээ.

### **Зөвлөлдөх уулзалтууд**

Батлан хамгаалах салбарын бодлогыг хөгжүүлэх, хоёр талын үйл ажиллагааг зохицуулах, өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх хамтын ажиллагааны хэлбэр нь хоёр талын дээд, дунд хэмжээний Зөвлөлдөх уулзалт билээ. Ийм уулзалтыг 2000 оноос эхлэн жил бүр зохион байгуулж, дэлхий болон бүс нутгийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлаар санал солилцох, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хэтийн төлөв, чиглэлийг улс төрийн бодлогын түвшинд тодорхойлох, батлан хамгаалах бодлогын асуудлаар харилцан туршлага солилцох хүрээнд зохион байгуулсаар ирсэн.

Зөвлөлдөх уулзалтаар хоёр тал бүс нутгийн аюулгүй байдлын зарим асуудал, тус тусын батлан хамгаалах, цэргийн бодлогын тодорхой асуудлаар мэдээлэл хийж, санал бодлоо солилцож ирсэн нь хамтын ажиллагаанд харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй, хоёр орны батлан хамгаалах, зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааг, хэрэгжиж буй хөтөлбөр төслийн явц байдлыг хэлэлцэн дүгнэж, цаашид анхаарал хандуулах асуудлыг тодорхойлж ирсэн нь хамтын ажиллагааны өгөөжийг сайжруулахад чухал үр дүнтэй арга хэмжээ гэж үзэж болохоор байна.

1999 оноос эхэн хоёр талын батлан хамгаалах салбарын дунд хэмжээний зөвлөлдөх уулзалтыг жил бүр хийж, хамтын ажиллагааны өнгөрсөн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, дараагийн

жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэх, хоёр орны батлан хамгаалах салбарт гарч буй өөрчлөлттэй жилийн төлөвлөгөөг уялдуулах болон цэргийн байгууллагын үйл ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцох зорилгоор зохион байгуулж байсан. 2010 оноос дунд хэмжээний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулаагүй, тасалдсан хэдий ч, 2016 оны дээд хэмжээний зөвлөлдөх уулзалтаар дунд хэмжээний зөвлөлдөх уулзалтыг сэргээх талаар харилцан тохиролцоод байна.

Хоёр талын үйл ажиллагааны чиглэлээр “Монгол улсын батлан хамгаалах салбарын шинэчлэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх дунд хэмжээний ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж байна. Энхийг сахиулах ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай болгоход АНУ-ын зүгээс батлан хамгаалах, зэвсэгт хүчинд үзүүлж буй тусламж, дэмжлэгийг чиглүүлэх зорилгоор энэ хөтөлбөрийг боловсруулжээ. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдах зөвлөлийн хурлыг батлан хамгаалах, зэвсэгт хүчний дээд болон дунд хэмжээний зөвлөлдөх уулзалтын үеэр, харин хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг зөвлөлдөх уулзалтын өмнө хийдэг уламжлал тогтоод байна. Ийнхүү хоёр орны батлан хамгаалах, зэвсэгт хүчний харилцааг тодорхой зорилго, чиглэлтэйгээр өргөжүүлж, хөгжүүлэх зөвлөлдөх механизмыг бүрдүүлээд байна.

### **Хамтарсан сургалт, семинар**

Монгол-Америкийн батлан хамгаалах, зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагааны нэг үндсэн чиглэл нь хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах хэлбэр болсон байна.

Монгол Улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб нь АНУ-ын Батлан хамгаалах яам, Номхон далай дахь АНУ-ын цэргийн хүчний командлалтай хамтран Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын цэргийн ар талын байгууллагын Зохион байгуулах Хорооны (Project Development Committee meeting) хуралдаан (2000 он), Зүүн хойд Азийн энхийг сахиулах ажиллагааны дадлага-семинар (2002 он), Зүүн хойд Азийн аюулгүй байдлын симпозиум (2002 он), Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Олон үндэстний төлөвлөлтийн өргөтгөсөн багийн команд-штабын сургууль (2003 он)-ийг тус тус

Улаанбаатар хотод зохион байгуулсан байна.

Номхон далай дахь АНУ-ын цэргийн хүчний командлал, Дэлхийн энхийг дэмжих санаачилга хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад болон Ази-Номхон далайн орнуудад зохион байгуулагддаг сургалт, дамжаанд Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдыг оролцуулж байна.

Монгол-Америкийн батлан хамгаалах, зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагааны нэг хэлбэр нь хамтарсан сургалт, семинарыг явуулахыг дурдаж болно. 1997 оноос эхлэн манай улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчний тулгамдсан асуудлаар АНУ-ын мэргэжилтэн, багш нарыг ирүүлж, хамтарсан семинар, сургалтыг зохион байгуулж байгаа билээ. Төрийн байгууллагын албан хаагчдыг хамруулсан “Цэрэг-иргэний харилцаа”, “Төрийн ёс зүй”, “Олон улсын терроризмтой тэмцэх”, “Энхийг сахиулах ажиллагааны эрх зүйн асуудал”, “Мэргэжлийн ахлагч бэлтгэх тулгамдсан асуудал” сэдэвт хамтарсан семинарыг зохион байгуулж, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад зохих мэдлэгийг эзэмшүүлжээ. Түүнчлэн, Олон улсын эрх зүй судлалын Батлан хамгаалахын хүрээлэн Зэвсэгт хүчний Жанжин штабтай хамтран “Мэргэжлийн ахлагч нарын эрх зүйн асуудлууд”, Батлан хамгаалахын захиргааны хяналтын албатай хамтран “Төрийн хяналт шалгалт” сэдвээр семинарыг тус тус зохион байгуулжээ.

Монгол-Америкийн хамтран зохион байгуулсан сургалтын оргил нь 2006-2016 онд зохион байгуулсан “Хааны эрэлд” олон улсын хамтарсан энхийг дэмжих ажиллагааны сургууль билээ. “Хааны эрэлд” хамтарсан сургууль нь дан ганц тактикийн хээрийн сургууль бус команд-штабын болон хүмүүнлэгийн сургуулийг багтаасан иж бүрэн сургууль болж өргөжсөн байна. “Хааны эрэлд” сургуульд оролцож байгаа улс орны тоо жилээс жилд нэмэгдэж, 2011 онд 11 улс оролцож байсан бол 2016 онд 46 улс оролцсон бүс нутгийн томоохон хээрийн сургууль болж өргөжсөн байна. 2011 онд хээрийн сургуульд монголын 600 гаруй, гадаадын 160 цэргийн албан хаагч оролцож байсан бол 2016 онд монголын 1100, гадаадын 870 цэргийн албан хаагч оролцсон байна.

Монгол Улсын Засгийн газар энэ сургуулийг зохион байгуулах нь бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд томоохон хувь нэмэр

оруулж байгааг үнэлж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Энхийг сахиулах ажиллагааны бүс нутгийн сургалтын төв” байгуулах зорилтыг тусгаж, энэ сургуулийг зохион байгуулахад зохих төсвийг гаргахад дэмжлэг үзүүлж ирлээ. 2011 онд “Хааны эрэлд” сургуулийг зохион байгуулахад 326 сая төгрөгийн санхүүжилтийг Монголын талаас гаргаж байсан бол 2016 онд 2.5 тэрбум төгрөгийг зарцуулах болжээ. Энэ Монголын Улсын Засгийн газраас энэ сургуулийг тогтмол явуулахад бодлогын болон бусад дэмжлэгийг үзүүлж байгаагийг илрэл юм.

Хоёр талын хамтарсан өөр нэг сургууль бол иргэний хамгаалалтын “Баланс Мэжик” дадлага бөгөөд энэ сургуулиар хоёр талын цэргийн албан хаагчдыг байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын үр дагаварыг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх чиглэлээр харилцан туршлага солилцох зорилготой зохион байгуулдаг болжээ. Харин 2013 оноос энэхүү сургуулийг хоёр талын тусгай хүчний хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох чиглэлээр зохион байгуулж ирлээ. Тусгай хүчний хамтарсан “Баланс Мэйжик” сургалт, дадлагыг жил бүр Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй зохион байгуулж байгаа нь тусгай ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чухал арга хэмжээ болж байна.

### **Хамтарсан ажиллагаа**

Монгол Улс Зэвсэгт хүчний цэргийн багийг түүхэндээ анх удаагаа олон улсын эвслийн цэргийн ажиллагаанд оруулахаар 2003 онд шийдвэрлэсэн нь АНУ-ын тэргүүлсэн “Иракийн эрх чөлөө ажиллагаа”-нд цэргийн хамгаалалтын ротыг илгээх шийдвэр байлаа. Энэ нь Монголын цэргийн алба хаагчид өөр улстай хамтран үүрэг гүйцэтгэж эхлэн, улмаар НҮБ-ын ЭСА-нд бие даан цэргийн багийг оролцуулах боломжийг нээсэн чухал үйл явдал болсон билээ.

Ирак дахь олон улсын цэргийн ажиллагаанд 2003-2008 онд 10 ээлжинд нийт 3 штабын офицер, 1192 цэргийн албан хаагч үүрэг гүйцэтгэсэн<sup>1</sup> нь энхийг дэмжих ажиллагааны туршлагыг хуримтлуулсан чухал үе байлаа. Мөн 2003 оны 10 дугаар сараас Зэвсэгт хүчний сургалтын хөдөлгөөнт багийн 13 ээлжийн 265 цэргийн албан хаагч

<sup>1</sup> Susan V. Lawrence, Mongolia: Issues for Congress, September 3, 2014, <https://fas.org/sgp/crs/row/R41867.pdf>

“Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Афганистаны үндэсний армийн Артиллерийн бие бүрэлдэхүүнийг сурган, дадлагажуулах үүрэг гүйцэтгэжээ.

2009-2015 онд Кабул дахь АНУ-ын “Эггерс” баазын харуул, хамгаалалтын үүргийг 10 ээлжинд 1252 цэргийн албан хаагч, 2010-2014 онд нисдэг тэрэгний сургалтын хөдөлгөөнт багт 30 цэргийн албан хаагч тус тус үүрэг гүйцэтгэсэн байна.

### **АНУ-ын үзүүлсэн цэргийн тусламж**

АНУ-ын үзүүлж байгаа цэргийн буцалтгүй тусламж нь монголын цэргийн албан хаагчдыг сургаж бэлтгэх, Зэвсэгт хүчний энхийг энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэхэд үндсэндээ чиглэж ирлээ. АНУ-аас үзүүлсэн тусламжийн байдалд дүгнэлт хийх үзэхэд сургалт, боловсролын болон ЭДА-нд оролцох чадавхийг нэмэгдүүлэх гэсэн 2 чиглэлээр үзүүлсэн нь харагдаж байна.

Монголын цэргийн албан хаагчдын англи хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх, улмаар тэднийг АНУ-ын цэргийн сургууль, дамжаанд сургах хүрээнд АНУ-ын Олон улсын цэргийн боловсрол ба сургалтын хөтөлбөр (ИМЕТ<sup>2</sup>)-т хамруулж ирсэн билээ. Энэ хөтөлбөрт Монгол Улсыг үнэгүй хамруулж, 1992-2011 онд 13 сая ам.доллар-<sup>3</sup>ыг зарцуулсан байна. Энэ хөтөлбөрийн шугамаар 2012-2016 онд 5 сая ам.долларын санхүүжилтийг АНУ-аас хийсэн бол 2017 оны санхүүжилт 2 сая ам.доллар болж нэмэгдээд байна. Санхүүжилтийг хүснэгтээр харуулав.


Монгол Улс ба АНУ-ын батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж ирсэний нэг том илрэл нь Гадаадын цэргийн санхүүжилт (FMF<sup>4</sup>) хөтөлбөрт хамрагдах болсонд оршино. Энэ хөтөлбөрийн хүрээнд энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадавхийг бий болгох хүрээнд цэргийн зэвсэг, техникийг буцалтгүй тусламжаар нийлүүлэх боломжтой болжээ.

---

2 International Military Education and Training

3 Jonathan S. Addleton, *Mongolia and the United States: A Diplomatic History*, 2013

4 Foreign Military Financing



Мөн 2002-2004 онд Олон улсын энхийг сахиулах чадавхийг өргөжүүлэх хөтөлбөр<sup>5</sup>-ийн хүрээнд Монголын тал АНУ-ын талаас 2 сая ам.долларыг хүлээн авчээ<sup>6</sup>. Мөн “Дэлхийн Энхийн ажиллагааны санаачлага” (GPOI<sup>7</sup>) хөтөлбөрийн хүрээнд 10 сая ам.долларын техник хэрэгслийг хүлээн авсан байна. 2009 оны байдлаар 640 энхийг сахиулагч, 77 сургагч багш нарыг бэлтгэжээ<sup>8</sup>.

Энэ хөтөлбөрийн хүрээнд 2009-2016 онд Монгол Улсад НҮБ-ын цэргийн ажиглагч, штабын болон ар талын офицер, сургагч багшийн 22 дамжааг зохион байгуулж, нийт 564 цэргийн албан хаагч хамрагдсаны Монголын 407 цэргий албан хаагч суралцжээ. Үүний дотор НҮБ-ын ЭСА-нд 45 цэргийн ажиглагч, 20 штабын офицер үүргээ амжилттай гүйцэтгэж, өнөөдрийн байдлаар 15 цэргийн албан хаагч үүргээ гүйцэтгэж байна<sup>9</sup>. Сүүлийн 6 жилд Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд АНУ-аас үзүүлсэн тусламжийн хэмжээг хүснэгтээр харуулав.

5 Enhanced International Peacekeeping capabilities program.

6 Jonathan S. Addleton, Mongolia and the United States: A Diplomatic History, 2013

7 Global Peace Operation Initiative

8 Nina M. Serafino The Global Peace Operations Initiative: Background and Issues for Congress June 11 2009

9 <http://www.mod.gov.mn/index.php?com=news&id=696>

	2011	2012	2013	2014	2015	2016
<b>GPOI</b>	\$5,083,000				\$375,000	\$1,270,000
<b>FMFP</b>	\$5,000,000	\$3,000,000	\$3,000,000	\$2,400,000	\$2,000,000	\$1,624,000
<b>T-10</b>					\$608,412	
<b>IMET</b>	\$1,000,000	\$1,000,000	\$755,000	\$825,000	\$1,500,000	\$2,000,000

2009-2013 онд АНУ-аас буцалтгүй тусламжаар Энхийг дэмжих ажиллагаанд оролцох гурван батальоны иж бүрэн холбооны хэрэгсэл, Англи хэлний сургалтын иж бүрэн танхим, 1100 хүний нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, 68 нэгж “Форд” загварын тусгай зориулалтын автомашин, 9 нэгж барилга инженерийн техник хэрэгсэл, лазерийн хол хэмжигч олгосны дээр Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн хичээлийн байр, цэргийн болон штабын байрны иж бүрэн засварыг хийж өгсөн.

Олон улсын стандарт шаардлагыг хангасан энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийг бэхжүүлж засварлахад 2015 онд АНУ-аас 6.5 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжийг Монгол тал авсан байна<sup>10</sup>. Мөн 2015 онд Үүнээс гадна 4.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий “Харрис” радио станцийг ЭДА-ны 3 дахь батальонд, 207 сая төгрөгийн өртөг бүхий англи хэлний ярианы дадлагын танхим, тоног төхөөрөмж, ном сурах бичиг, 4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 35 нэгж “Вранглер” автомашин, 2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 35 нэгж “Тоёота” авто машиныг АНУ-ын санхүүжилтээр хүлээж аваад байна.

### Цаашдын төлөв

Монгол-Америкийн батлан хамгаалах салбарын ойр ирээдүйн төлвийг Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, АНУ-ын Батлан хамгаалахын сайд Ч.Хэйгел (Chuck Hagel) нарын хамтарсан мэдэгдэлд тодорхойлсон гэж үзэж байна. Энэ мэдэгдэл<sup>11</sup>-ийг 2014 онд АНУ-ын Батлан хамгаалахын Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр гаргасан билээ.

<sup>10</sup> Ч.Баттулга. “Монгол, АНУ-ын батлан хамгаалах салбарын харилцаа” Цэргийн шинэчлэл сэтгүүд. 2010 он.

<sup>11</sup> Department of Defense, Joint Vision Statement for the U.S.-Mongolia Security Relationship,” April 10, 2014, <http://www.defense.gov/pubs/FINAL-US-Mongolia-Joint-Vision-Statement-V7.pdf>.

Энэ мэдэгдэлд дараах үндсэн асуудлыг тусгажээ. Үүнд:

- АНУ нь энхийг дэмжих болон хүмүүнлэгийн тусламжийг үзүүлэх ажиллагаанд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сайшааж, энэ чиглэлийн чадавхийг нэмэгдүүлэхэд үзүүлэх дэмжлэг, тусламжаа үргэлжлүүлэх;
- “Хааны эрэлд” олон улсын хамтарсан сургууль хоёр орны олон талт батлан хамгаалах хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгааг үнэлээд энэ талын ажиллагааг улам бэхжүүлж, бүс нутгийн жишиг хээрийн сургууль болгоход анхаарах;
- 2012 онд АНУ нь НАТО-гийн Дэлхийн түншлэлийн статусыг хүлээн зөвшөөрсөн улсын хувьд НАТО-гийн бусад улстай хөгжүүлж байгаа Монголын Зэвсэгт хүчний сургалт, мэргэжлийн хөгжил ба шинэчлэлийн түншлэлийн санаачлагыг дэмжиж, НАТО-гийн ажиллагаан дахь хамтын ажиллагаа болон харилцан ажиллагааг хөгжүүлэх;
- Америкийн тал батлан хамгаалах, зэвсэгт хүчний хамтын ажиллагааны хүрээнд дээд түвшний бодлогын яриа хэлэлцээгээ үргэжлүүлэх, Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчний шинэчлэлийг бүхий л талаар дэмжихийн хамт цэргийн боловсролыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хоёр улсын цэргийн байгууллага, бие бүрэлдэхүүн, үүний дотор сургалтын байгууллагын уялдаа холбоог өргөжүүлэх, мөн Аляск мужийн Үндэсний гвардтай хөгжүүлж байгаа Улс, муж хоорондын түншлэлийн хөтөлбөрийг дэмжих, оролцооны уялдаа холбоог сайжруулах;
- Зэвсэгт хүчний энхийг дэмжих, хүмүүнлэгийн болон гамшгийн үеийн тусламжийн ажиллагаанд оролцох чадавхийг хөгжүүлэх, өргөжүүлэх арга замыг эрэлхийлэх, “Таван толгой” дахь сургалтын төвийг бүс нутгийн төв болгох;
- Хамтарсан сургалт ба хээрийн сургуулийг төгөлдөржүүлэх арга замыг эрэлхийлэх, олон улсын хээрийн сургуульд оролцох, ажиглах боломжийг нэмэгдүүлэх, харилцан ажиллах ба практик хамтын ажиллагааг өргөжүүлэх хүчин чармайлтыг нэмэгдүүлэх;

- Монгол-Америкийн батлан хамгаалах хамтын ажиллагааг өргөжүүлэх арга замыг үргэлжлүүлэхээ төлөвлөх зэрэг болно.
- Монгол-Америкийн харилцаа, хамтын ажиллагааны арга хэмжээнүүдийг америкийн талтай тохиролцон жилээр нь төлөвлөж хэрэгжүүлж ирсэн бөгөөд цаашид “Монгол Улсын Батлан хамгаалахын шинэчлэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд хамтарсан хөтөлбөр, төслүүдийг чиглүүлэхэд онцгойлон анхаарах нь дамжиггүй. Энэ хүрээнд БХЯ нь доорх үндсэн чиглэлүүдэд ач холбогдол өгч ажиллаж байгаа нь харагдаж байгаа болно<sup>12</sup>. Үүнд:
- Ази-Номхон далай, түүний дотор Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдал болон харилцан сонирхсон бусад асуудлаарх зөвлөлдөх механизмын үйл ажиллагааг үргэлжлүүлэх, тогтмолжуулах;
- Олон улсын терроризмтэй тэмцэх талаарх АНУ-ын зүгээс явуулж буй үйл ажиллагаа хоёр талын харилцаанд чухал байр суурь эзэлсэн хэвээр байх тул энэ талаарх АНУ-ын тэргүүлсэн эвслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- АНУ-ын Олон улсын цэргийн сургалт боловсролын болон өргөтгөсөн E-IMET хөтөлбөрүүдийн хүрээнд монголын цэргийн алба хаагчдыг АНУ-ын цэргийн сургууль, дамжаанд үргэлжлүүлэн сургах, батлан хамгаалах, зэвсэгт хүчний сургалт, боловсролын тогтолцоог олон улсын түвшинд хүргэхэд АНУ-ын дэмжлэг, туслалцааг авах;
- Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаа болон олон талт үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэхэд АНУ-аас дэмжлэг, туслалцааг авах;
- Ази, Номхон далай бүс нутагт зохиогдож буй олон талт арга хэмжээ, команд-штабын сургууль болон хээрийн дадлагад манай улсыг оролцуулахад АНУ-ын дэмжлэгийг авах, мөн АНУ-тай хамтран олон улсын энхийг дэмжих ажиллагааны дадлага, сургуулийг манай улсад үргэлжлүүлэн зохион байгуулах;
- Зэвсэгт хүчинд ардчилсан, иргэний хяналт тавих механизмыг төгөлдөржүүлэхэд дэмжлэг авах;

---

12 Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг сахиулахын цагаан ном, 2015 он, 180-р тал

- АНУ-ын Аляск мужийн Үндэсний гвардитай байгуулсан “Улс, муж хоорондын түншлэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, гамшгийн болон энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, харилцан туршлага солилцож, хамтран ажиллах;
- Мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэх, ахлагчийн тогтолцоог боловсронгуй болгох, энхийг дэмжих ажиллагаанд оролцох чиг үүрэг бүхий анги, салбарын бие бүрэлдэхүүний англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтын тогтолцоог бий болгоход АНУ-ын тусламж, дэмжлэгийг авах;
- Цэргийн эмнэлгийн шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;
- Кибер аюулгүй байдлын чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлэх зэрэг тус тус болно.

### **ДҮГНЭЛТ.**

1. Монгол-Америкийн батлан хамгаалах, зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн хөгжлийг 3 үе шат болгох авч үзэх боломжтой байна. Үүнд:

- Эхний шат, 1991-1996 он. Энэ шатанд Зэвсэгт хүчний цэргийн албан хаагчдад англи хэлний сургалт явуулах нөхцлийг бүрдүүлэх, цэргийн дээд түвшний харилцан айлчлал хийж эхэлсэн үе.
- 2 дугаар шат, 1996-2006 он. Цэргийн мэргэжилтнүүдийг харилцан солилцох Засгийн газар хоорондын гэрээнд гарын үсэг зурж, гэрээний дагуу Монголын цэргийн алба хаагчдыг АНУ-ын цэргийн сургуульд суралцуулж эхэлсэн байна. Мөн АНУ-ын дэмжлэгтэйгээр хамтарсан команд-штабын сургуулийг зохион байгуулж, энэ сургуульд америкийн цэргийн албан хаагчид оролцох болжээ.
- 3 дугаар шат. 2003-аас өнөөг хүртэл. Энэ шатанд Монголын цэргийн багууд Афганистан, Иракийн олон улсын цэргийн ажиллагаанд АНУ-ын цэргийн удирдлагад оролцох болсноор Монгол-Америкийн батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа түншлэлийн түвшинд хүрсэн гэж дүгнэж болох юм. Монгол Улсын энэ оролцоог АНУ өндөр үнэлдэг.

2. АНУ-тай хамтран олон улсын ажиллагаанд хамтран үүрэг гүйцэтгэж, улмаар Зэвсэгт хүчний офицерууд АНУ-ын цэргийн сургуульд, дамжаанд хамрагдаж, боловсрол чадвар нь олон улсын түвшинд хүрснээр Монгол Улсын цэргийн алба хаагчид, багууд энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хэмжээнд гарсан нь Монгол-Америкийн батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны үр дүн гэж үзэж байна.

3. АНУ-ын зүгээс Монголын энхийг сахиулах чадавхийг нэмэгдүүлэхэд үзүүлсэн техникийн тусламж нь Зэвсэгт хүчнийг энхийг дэмжих ажиллагааны шаардлагыг хангасан тээврийн, холбооны болон эмнэлгийн техник хэрэгслээр хангахад түлхэц өгч, ажиллагааны газар оронд тавигдсан үүргээ амжилттай биелүүлэх боломжийг бүрдүүлжээ.

2016 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар Монгол Улс нь НҮБ-ын цэрэг илгээгч улсуудын жагсаалтын 29 дүгээр байран орж, Баруун Сахар (MINURSO), Конго (MONUSCO), Дарфур (UNAMID), Өмнөд Судан (UNMISS) болон Афганистан (UNAMA) НҮБ-ын 6 ажиллагаанд 950<sup>13</sup> (үүний дотор 81 эмэгтэй) цэрэг, цагдаагийн албан хаагч үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь Зэвсэгт хүчний нэг хүнд ноогдох энхийг сахиулагчдын тоогоор дээгүүр байр эзлэх нь дамжиггүй. Өмнө нь Монголын цэргийн албан хаагчид Либери (UNMIL), Чад, Төв Африк (MINURCAT), Судан (UNMIS, Этиоп ба Эритрий (UNMEE) болон Гүрж дэх (UNOMIG) НҮБ-ын ЭСА-нд тус тус үүрэг гүйцэтгэж байжээ.

4. Зэвсэгт хүчний “Таван толгой” дахь сургалтын төв нь орчин үеийн техник хэрэгсэлтэй, олон улсын томоохон хээрийн сургуулийг явуулах материаллаг баазтай болсноор бүс нутгийн орнуудын энхийг дэмжих чадавхийг нэмэгдүүлэхэд Монгол Улсын оруулах хувь нэмрийг бэхжүүлж, энэ төвийг бүс нутгийн хэмжээний сургалтын төв болгоход АНУ-ын дэмжлэг ихээхэн оржээ.

\* \* \*

---

13 United Nations, “Contributors to United Nations Peacekeeping Operations: Monthly Summary of Contributions, United Nations, Ranking of military and police contributions, [http://www.un.org/en/peacekeeping/contributors/2016/Nov16\\_2.pdf](http://www.un.org/en/peacekeeping/contributors/2016/Nov16_2.pdf)

## **И. Батболдын товч намтар**

Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн судлаач, докторант. Хурандаа цолтой.

1986-1995 онд Зэвсэгт хүчний анги салбарт салаа, салбарын захирагч, албаны дарга, тасгийн дарга-инженер, Армийн Тооцоолон шинжлэх станц, 1997-2000 онд ЗХ-ний Тооцоолон бодох төвд захирал, 2000-2008 онд ЗХЖШ-ний Цэргийн удирдлага, стратегийн төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2008 онд БХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академид багш, ахлах багш, тэнхимийн дарга, 2008-2010 онд БХЯ-ны СУТГ-т мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, тасгийн дарга, газрын орлогч дарга, 2010-2013 онд БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, 2013-2016 онд НҮБ-ын дэргэдэх Байнгын төлөөлөгчийн газрын Цэргийн зөвлөхөөр тус тус ажилласан.

Баруун Сахар дахь НҮБ-ын ЭСА-нд цэргийн ажиглагч, Сьерра Леоне дахь НҮБ-ын ЭСА-нд Цэргийн багийн захирагч, АНУ-ын Төвийн командлалд холбогч офицероор үүрэг гүйцэтгэсэн.

\* \* \*